




ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Дорноговь аймгийн
нийгэм, эдийн засгийн
танилцуулга

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2018/6



Мэдээллийн нэгдсэн лавлах: WWW.1212.MN

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2018 оны 06 дугаар сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт



1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2018 оны 06 сард 664 эх амаржиж, 666 хүүхэд шинээр мэндэлжээ. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 26(4.1%)-аар, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 28(4.4%)-аар, 191 хүн нас барсан нь 6(3.2%)-аар тус тус өссөн байна.

Хүн амын цэвэр өсөлт 475 болж өмнөх оны мөн үеэс 22(4.9%)-оор өсчээ. 1000 хүнд ногдох төрөлт 9.9, нас баралт 2.8 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.1 пунктээр өсч, нас баралт өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2015-2018 оны 06 сард



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд нялхсын эндэгдэл 10 байгаа нь өмнөх оны мөн үеэс 4-өөр их байна.



1.2 Эрүүл мэнд

2018 оны 06 сарын байдлаар 180.2 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар, 9.0 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 4.7 хувиар тус тус өсч, 5.6 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар буурсан байна.


2018 оны 06 сард 800 эх жирэмсний хяналтанд орсны 87.1 хувь буюу 697 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар буурсан байна.



Түргэн тусламжийн дуудлага 10.3 мянган удаа гарсны 1.7 мянга буюу 16.5 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 5.1 хувиар өсч, алсын дуудлага адил хэмжээнд байна.

Он гарсаар ослын улмаас 1593 хүн бэртэж, 44 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 241 (17.8%)-ээр нэмэгдэж, нас барсан хүний тоо 5(10.2%)-аар буурсан байна.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2018 оны 06 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд цусны эргэлтийн тогтолцооны өвчин 26.7 хувь, осол гэмтэл, хордлого гадны шалтгаант нас баралт 23.0 хувь, хавдар 20.9 хувь, хоол шингээх эрхтний тогтолцооны өвчин 8.4 хувь, бусад төрлийн өвчин 20.9 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 359 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 128 (26.3%)-аар буурчээ. Халдварт өвчний тохиолдол буурахад вирус гепатит 71.4 хувь, тэмбүү 22.6 хувь, трихоминиаз 4.3 хувь, бусад төрлийн өвчин 63.5 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

1.3 Соёл, боловсрол

Аймгийн соёл урлагын байгууллагууд эхний 6 сарын байдлаар 25.6 мянган хүнд үйлчилж, 21.0 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Аймагт үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн урлагийн байгууллага 112 удаагийн тоглолт хийж, музейнүүд дотоод, гадаадын 2.5 мянган хүнд үйлчилсэн байна.

2017/2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийг бага, суурь, бүрэн дунд боловсролоор 3156 суралцагч төгссөн нь өмнөх оны мөн үеэс 466(17.3%)-аар илүү байна. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Төмөр замын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, ЭМШУИС-ийн салбар сургуулийг 585 оюутан суралцаж төгссөн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 3 (0.5%)-аар өсчээ.




1.4 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2018 оны 06 сарын эцэст 926 болсны 914 (98.7%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 12 (1.3%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 737 (55.7 %) хүнээр буурч, өмнөх сараас 66(7.7%) хүнээр өссөн байна. Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 436 (47.1%) нь эмэгтэйчүүд бөгөөд 432 (46.6%) нь Сайншанд суманд, 160 (17.3%) нь Замын-Үүд суманд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 62.1 хувь нь бүрэн дунд, 18.1 хувь нь дээд, 6.2 хувь нь техник болон мэргэжлийн, 6.0 хувь нь бүрэн бус дунд, 4.3 хувь нь тусгай дунд, 2.5 хувь нь боловсролгүй, 0.6 хувь нь бага, 0.1 хувь нь магистр/докторын боловсролтой иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2018 оны 06-р сард




Хөдөлмөрийн хэлтэст он гарсаар 1264 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 164 иргэн ажилд зуучлагдан орж, 93 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна

Ажлын байрны захиалга 245 бүртгэгдсэний 130 (53.1%) нь уул уурхайн олборлох аж үйлдвэр, 22 (8.9%) нь төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, 19 (7.7%) нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 18 (7.3) хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээний салбарт байна. Ажил хайгч 164 иргэн хөдөлмөрийн байгууллагаар дамжуулан ажилд зуучлуулан орсны 71 (43.3%) нь эмэгтэйчүүд байна.

Зураг. Бүртгээгүй ажилгүй иргэд сумаар



Зураг. Шинээр ажлын байранд орсон иргэд салбараар



1.5 Нийгмийн даатгал, халамж

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 06 сард 16455.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2619.2 (18.9%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 06 сард өмнөх оны мөн үеэс 18.9 хувиар нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 1989.2 (23.8%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сан 331,5 (24.0%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 225.5 (23.8%) сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2018 оны 03 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 22196.4 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 2921.6 (15.2%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 15884.7 (71.6%) сая.төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 3441.3 (15.5%) сая



төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 1238.3 (5.6%) сая.төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 1265.4 (5.7%) сая.төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 366.7 (1.7%) сая төгрөгийг зарцуулжээ.


Зураг. Нийгмийн даатгалын зарлага, сая төг




Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээгээр 2018 оны эхний 06 сард нийгмийн халамжийн сангаас 21761 иргэнд 4050.2 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 5639 (35.0%)-өөр, олгосон тэтгэвэр тэтгэмж 1142.7 (39.3%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Халамжийн тэтгэвэр, тэтгэмж өсөхөд насны хишиг, цалинтай ээж хөтөлбөрт 5839(26.8%) иргэн хамрагдаж, 1088.5(26.9%) сая төгрөгийн тэтгэмж олгосон нь нөлөөлсөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2018 онд хүн хамрагдсан нь өмнөх оноос 32 (2.5%)-аар, олгосон тэтгэвэрийн хэмжээ 390.7 (53.5%) сая төгрөгөөр нэмэгджээ. Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжид 1036 иргэнд 377.2 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 951 иргэнд 307.4 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 7702 иргэнд хамруулж 439.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Нийгмийн бусад халамжийн шаардлагатай иргэнд үзүүлэх тусламжийг 10747 иргэнд 1805.6 сая төгрөг олгосон байна.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /мян төг/



1.6 Гэмт хэрэг


Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр оны эхний хагас жилийн байдлаар 293 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 66 хүн гэмтэж, 12 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 23(8.7%)-аар, гэмтсэн хүний тоо 46(41.1%) - аар тус тус буурч, гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо өмнө оны мөн үеийнхтэй адил байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 18(72.0%)-аар, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3(30.0%)-аар, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 2(28.5%)-оор, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 3(3.9%)-аар буурч, авилгын гэмт хэрэг, цэргийн албаны эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 123(42.0%) нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 74(25.3%) нь хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 33(11.3%) нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргүүд эзэлж байна. Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 31 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 76(71.0%) -аар буурсан байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Айраг, Өргөн, Сайхандулаан, Эрдэнэ, Сайншанд, Замын-Үүд сумдад буурсан байна.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 494.3 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2521.4(83.6) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 328.3(66.4%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 81(27.6%) нь гэр сууцандаа, 40(13.7%) нь гудамж олон нийтийн газарт, 31(10.6%) нь согтуугаар, 13(4.4%) бүлэглэн, 30(10.2%) хувийг эмэгтэй хүн оролцон, 105(35.8%) нь шөнийн цагаар /22.00-06.00 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 665 хүн эрүүлжүүлэгдэж, 132 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 06 сард




Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт



2.1 Мөнгө, зээл

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын кассын орлого 717.7 тэрбум төгрөг болж өмнөх оноос 162.2(29.2%) тэрбум төгрөгөөр өсч, цэвэр зарлага 730.0 тэрбум төгрөг болж 199.1(37.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2017- 2018 он, мян.хүн



Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2017-2018 он, сая.төг




Иргэдийн мөнгөн хадгаламж 93.3 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1035.6 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дунджаар 1367.9 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж эзэмшигчийн тоо 24.0(36.2%) мянган хүнээр, хадгаламжийн үлдэгдэл 24.5(35.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 06 дугаар сарын эцэст 1899.0 сая төгрөг болж, өмнөх сараас 341.9(15.3%) сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 375.8(16.5%) сая төгрөгөөр буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.8 хувийг эзэлж, өмнөх сараас 0.2 пунктээр, өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр буурчээ.

Чанаргүй зээл 06 дугаар сарын эцэст 8218.6 сая төгрөг болж өмнөх сараас 433.6(5.0%) сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 106.2(1.3%) сая төгрөгөөр буурсан. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.9 пунктээр буурсан байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2018.06 сард




Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2018.06 сард



2.2 Орон нутгийн төсөв

2018 оны 06 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 13928.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 103.4 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 37.6 хувиар өссөн байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 73.9 хувийг татварын, 26.1 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2018 оны 06-р сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 2444.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 297.3(13.8%) сая.төг-өөр нэмэгдэж, тухайн оны төлөвлөгөөнөөс 918.0(60.1%) сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2018 оны 06 дугаар сард өмнөх сараас 0.6 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар өсчээ.


Ерөнхий индекс өмнөх сараас 0.6 хувиар өсөхөд: хүнсний бараа, ундаа усны бүлэг 0.6 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодисын бүлэг, 1.1 хувь, хувцас бөс барааны бүлэг 0.1 хувь, орон сууц, ус, цахилааны, түлшний бүлэг 0.9 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 0.2 хувь, тээвэр 0.4 хувь, амралт чөлөөт цаг соёлын барааны бүлэг

0.4 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 3.7 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлэг 1.5 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 06 дүгээр сарын өөрчлөлт, өмнөх сартай харьцуулсанаар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 06 дугаар сарын өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)




Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт



3.1 Хөдөө аж ахуй

Оны эхний 06 сарын байдлаар төллөвөл зохих эх малын 71.4 хувь буюу 604.0 мянган толгой мал төллөж, төл бойжилт 97.5 хувьтай байна. Өмнөх оны мөн үеийнхээс төллөсөн хээлтэгч 33.9(5.9%) мянган толгойгоор, төл бойжилт 20.7(3.6%) мянган толгойгоор илүү юм.

Зураг. Том малын зүй бусын хорогдол, толгой



Эхний 6-н сарын байдлаар 8617 том мал хорогдож өмнө оны мөн үеэс хорогдол 6.5(4.1 дахин) мянган толгойгоор нэмэгдсэн байна. Хорогдол нэмэгдэхэд Дэлгэрэх, Иххэт сумдын нутаг дэвсгэрээр 4-р сард нойтон цас орж, хүчтэй цасан шуурга шуурч байгалийн онц аюултай үзэгдэл болж, Дэлгэрэх суманд 2.2 мянган толгой мал, Иххэт суманд 2.2 мянган толгой мал, Даланжаргалан суманд 1.2 мянган толгой мал хорогдсон нь голлон нөлөөлсөн байна.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн судалгаагаар Сайншанд суманд 06-р сард ноолуурын дундаж үнэ 70000 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 7000 (9.1%) төг-өөр буурсан байна. Харин ингэний сүү 2500 төг, үхэрийн шир 10.0 мянган төгрөг, хонины арьс 2.0 мянган төг-ийн ханштай байна. Эр хонь 110.0-180.0 мян.төг, эр ямаа 70.0-150.0 мян.төг-өөр худалдаалагдаж байна.



3.2 Аж үйлдвэр

Оны эхний 06 сард аж үйлдвэрийн салбарт 101390.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 133430.9 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2.1 дахин, борлуулалт 43.9 хувиар тус тус өссөн байна.

2018 оны эхний 6 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2.1 дахин өсөхөд уул, уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 15429.3 сая төгрөгөөр, боловсруулах салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 37594.6 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 3.9 хувийг төрийн, 96.1 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 3.9 хувь, компани 95.8 хувь, өрхийн аж ахуй 0.3 хувийг тус тус эзэлж байна.


Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй сувагжуулалт 51.3 мян.м3-ээр, нарийн боов 9.2 тонноор, бялуу 0.2 тонноор, сүүн бүтээгдэхүүн 2 мян.литрээр, вакуум цонх 508.7 м2-аар, цемент 214.9 мян.тонноор, блок 0.2 мян.ширхгээр, модон эдлэл 18675.3 мян.төгрөгөөр, дээл 101 ширхэгээр, жижиг оёдол 4840.6 мян.төгрөгөөр тус тус илүү үйлдвэрлэгджээ.



3.3 Барилга угсралт, их засвар

2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт 171560.9 сая төгрөгийн шинэ барилга, өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажил хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 5.8 дахин нэмэгдсэн байна. Барилгын нийт хөрөнгө оруулалтын 26.0 хувийг улсын төсвийн, 0.9 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, үлдэх хувийг хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ.

Зураг. Барилга угсралт, их засварын ажил, төрлөөр, мян төг



Барилга угсралт их засварын ажлын 94.2 хувь нь инженерийн барилга, байгууламж, 3.7 хувь нь орон сууцны барилга, 1.6 хувь нь орон сууцны бус барилга, 0.5 хувь нь их засварын ажил байна. Өмнөх оны мөн үеийнхээс орон сууцны бус барилгынх 70.7 пунктээр, орон сууцны барилгын эзлэх хувь 51.6 пункт, их засварын ажлынх 8.4 пунктээр буурч, инженерийн барилга, байгууламжийн эзлэх хувь 88.6 пунктээр өссөн байна.

Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



4.1 Байгаль орчин Цаг уур

2018 оны 06 дугаар сарын дундаж агаарын Дэлгэрэх, Мандах, Иххэт сумдад 21.1-21.9 хэм дулаан, бусад сумдын нутгаар 22.6-24.9 хэм дулаан, агаарын хамгийн их температур өдөртөө Иххэт суманд 34 хэм, Айраг суманд 35 хэм, бусад сумдын нутгаар 36-39 хэм дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж / ОЖД /-тай харьцуулахад: Нийт сумдын нутгаар ОЖД-аас дулаан байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө Иххэт суманд 5 хэм дулаан, бусад сумдын нутгаар 6-10 хэм дулаан, өдөртөө нийт нутгаар 60-69 хэм дулаан байв.

6 дугаар сард Мандах, Айраг сумдад огт хур тунадас ороогүй, сарын нийлбэр хамгийн их хур тунадас Иххэт суманд 12.8 мм, бусад сумдын нутгаар 1-6 өдөр хур тунадастай байж, 0.3-3.7 мм хур тунадас орлоо

Энэ сард салхины хамгийн их хурд Сайншанд суманд 29 м/с, Хөвсгөл суманд 25 м/с, Замын-Үүд суманд 23 м/с, Дэлгэрэх, Эрдэнэ сумдад 20 м/с, Сайхандулаан, Улаанбадрах сумдаас бусад сумдын нутгаар 16-18 м/с хүрч аюултай болон онц аюултай үзэгдлийн



хэмжээнд хүрсэн байна. 10м/с-ээс дээш салхитай хоногийн тоо Сайншанд суманд 25, Хөвсгөл, Замын-Үүд, Дэлгэрэх сумдад 20-23, Улаанбадрах суманд 5, Сайхандулаан суманд 9, бусад сумдын нутгаар 10-17 өдөр байлаа

_____ о Оо _____



АГУУЛГА

II. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдлын тухай статистикийн тоон мэдээлэл (Эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар)

- Нэг. Эрүүл мэнд
 - 1.1 Эрүүл мэнд
 - 1.2 Төрөлт, эх хүүхдийн эндэгдэл, сумаар
 - 1.3 Халдварт өвчний гаргалт, сумаар
 - Хоёр. Соёл, боловсрол
 - 2.1 Соёлын үзүүлэлтүүд
 - 2.2 Боловсролын үзүүлэлтүүд
 - Гурав. Хөдөлмөр эрхлэлт
 - 3.1 Ажилгүй иргэдийн тоо, боловсролын түвшингээр
 - 3.2 Ажилгүй иргэдийн тоо, сумаар
 - 3.3 Ажлын байрны захиалга, эдийн засгийн салбарын ангилалаар
 - 3.4 Ажлын байрны захиалга ажил мэргэжлийн ангилалаар
 - 3.5 Ажилд зуучилсан иргэд, ажил мэргэжлийн ангилалаар
 - 3.6 Шинэ ажлын байранд орсон иргэн, эдийн засгийн салбарын ангиллаар
 - Дөрөв. Нийгмийн даатгал, халамж
 - 4.1 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, төрлөөр
 - 4.2 Нийгмийн даатгалд заавал даатгуулагчийн тоо, олгосон тэтгэврийн хэмжээ
 - 4.3 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ
 - Тав. Гэмт хэрэг
 - 5.1 Бүртгэгдсэн хэргийн тоо төрлөөр, аймгийн дүнгээр
 - 5.2 Бүртгэгдсэн хэргийн тоо сумаар
 - Зургаа. Мөнгө, зээл
 - 6.1 Мөнгөн гүйлгээ, зээл
 - 6.2 Хадгаламж, зээл, сумаар, сарын эцэст
 - Долоо. Орон нутгийн төсөв
 - 7.1 Орон нутгийн төсвийн орлого, сая төгрөгөөр
 - 7.2 Орон нутгийн төсвийн зарлага, сая төгрөгөөр
 - 7.3 Орон нутгийн төсвийн орлого, зарлага, сумдаар, сая төгрөгөөр
 - 7.4. Улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлсэн орлого, сая төгрөгөөр
 - Найм. Үнэ
 - 8.1 Хэрэглээний үнийн индекс
 - 8.2 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф
 - 8.3 Гол нэрийн барааны үнэ, хөрш зэргэлдээ аймгуудаар
 - Ес. Хөдөө аж ахуй
 - 9.1 Мал төллөлт, төл бойжилт
 - 9.2 Том малын зүй бус хорогдол
 - 9.3 ХАА-н бүтээгдэхүүний үнийн судалгаа, төрлөөр
 - 9.4 Малын үнийн судалгаа, сумаар
 - Арав. Аж үйлдвэр
 - 10.1 Нийт бүтээгдэхүүн, борлуулалт, оны үнээр
 - 10.2 Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн жигд ажиллагаа
 - 10.3 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэд салбараар
 - 10.4 Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сумаар, нийт бүтээгдэхүүн гол нэр төрлөөр
 - Арван нэг. Барилга угсралт, орон сууц, нийтийн аж ахуй
 - 11.1 Барилга угсралт, их засварын ажил, төрлөөр, оны эцэст
 - 11.2 Барилга угсралт их засварын ажил, объектээр
 - Арван хоёр. Тээвэр
 - 12.1 Тээвэр
 - 12.2 Нефть хангамж
 - Арван гурав. Байгаль орчин
 - 13.1 Цаг уурын үзүүлэлт
- Тэмдэглэлийн тайлбар :
- (, ,) - тухайн тоо, баримт байхгүй
 - (0) - тайлант хугацаанд гүйцэтгэлгүй
 - (x) - энэ хүснэгтэнд тоо нөхөгдөхгүй
 - (.) - мэдээлэгдэх хугацаа болоогүй



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ
(2018 ОНЫ 6 ДУГААР САРЫН БАЙДЛААР)

750

I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018	2018 - 2017	2018
1. Бэлэн хүн ам	мянган хүн	63.1	66.6	68.2	68.5	0.3	100.4
- Төрсөн хүүхдийн тоо*	тоо	795	738	638	666	28	104.4
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	144	179	185	191	6	103.2
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	651	559	453	475	22	104.9
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	10	11	6	10	4	166.7
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	8.4	14.9	9.4	15.0	5.6	159.7
2. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	524	1390	487	395	-92	81.1
- 10000 хүнд ногдох	тоо	17.9	54	71	58	-13	81.1
3. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 451	1 018	1 663	926	- 737	55.7
- Үүнээс эмэгтэй	тоо	833	535	805	436	- 369	54.2
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	343	290	403	214	- 189	53.2
4. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	22	28	56	3	-53	5.4
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	20	28	56	3	-53	5.4
Улирлын чанартай ажлын байр	тоо	2	0	0	0	0	
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	295	353	321	293	-28	91.3
- 10000 хүнд ногдох ***	тоо	71	83	75	68	-7	90.8
6.Бойжиж буй төл, мян толгой	толгой	524952	466863	571231	591946	20715	104
- Ботго	толгой	5669	5931	6342	6512	170	103
- Унага	толгой	17733	11609	18331	19003	672	104
- Тугал	толгой	15869	11729	13737	15858	2121	115
- Хурга	толгой	248813	236137	283809	292632	8823	103
- Ишиг	толгой	236868	201457	249012	257941	8929	104
7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	5633.1	8520.3	48172.1	101390.1	53218.0	2.1 ²
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	5180.1	5276.9	92718.0	133430.9	40712.9	143.9

* - 2015, 2016, 2017 оны жилийн эцэст

**-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



II. ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

1.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 06 сарын эцэст

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-VI	2018 I-VI	Өсөлт	
		тоо			хувь
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	180.0	180.2	0.2	100.1
2. Ор хоног	мян.хүн	61.0	64.8	3.8	106.2
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	5.8	5.6	-0.2	96.6
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	8.6	9.0	0.4	104.7
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	9.8	10.3	0.5	105.1
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	1.7	1.7	0	100.0
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	1352	1593	241	117.8
Үүнээс: нас баралт	хүн	49	44	-5	89.8
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	787	800	13	101.7
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	688	697	9	101.3
8. Амаржсан эх	хүн	638	664	26	104.1
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	1	1	0	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	6	10	4	166.7

1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн эхний 06 сарын эцэст

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
	тоо				
Дүн	664	0	666	10	1
Айраг					
Алтанширээ					
Даланжаргалан					
Дэлгэрэх	1		1		
Иххэт	1		1		
Мандах					
Өргөн					
Сайхандулаан					
Улаанбадрах				1	
Хатанбулаг	1		1		
Хөвсгөл	1		1		
Эрдэнэ	3		3	1	
Сайншанд	533		534	5	
Замын - Үүд	124		125	3	1

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн эхний 06 сарын эцэст

Үзүүлэлт	2017 I-VI	2018 I-VI	Өсөлт	
	тоо		тоо	хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	487	359	-128	73.7
Вируст гепатит	7	2	-5	28.6
Сүрьеэ	49	49	0	100.0
Тэмбүү	62	48	-14	77.4
Заг хүйтэн	75	99	24	132.0
Трихоминиаз	46	44	-2	95.7
Цусан суулга	18	33	15	183.3
Бусад	230	84	-146	36.5

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар

84

ХОЁР. СОЁЛ, БОЛОВСРОЛ

2.1 СОЁЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	Хэмжих нэгж	2017 I-VI	2018 I-VI	Өсөлт	
		тоо		тоо	хувь
1. Театр -тоглолт	тоо	100	112	12	112.0
- шинэ уран бүтээл	тоо	0	0	0	0.0
- үзэгчид	мян.хүн	18.8	23.1	4.3	122.9
- орлого	мян.төг	24 663.0	18 105.5	-6 557.5	73.4
- хамрагдсан ААН	тоо	1	1	0.0	0.0
2. Музей					
- үзэгчид	мян. хүн	3.2	2.5	-0.7	78.1
- орлого	мян.төг	2 577.6	2 906.0	328.4	112.7
- хамрагдсан ААН	тоо	2	2	0	0.0

2.2 БОЛОВСРОЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	Хэмжих нэгж	2016	2017	2018	2018 2017
Төгсөлт-бүгд	тоо	2705	3272	3741	114.3
Үүнээс:					
Ерөнхий боловсролын сургууль	тоо	2190	2690	3156	117.3
Бага боловсрол	тоо	965	1136	1255	110.5
Суурь боловсрол	тоо	542	806	1050	130.3
Бүрэн дунд боловсрол	тоо	683	748	851	113.8
Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Төмөр замын мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв	тоо	259	349	422	120.9
ЭМШУИС-ийн салбар сургууль	тоо	256	233	163	70.0
ЕБС-ийн сурлагын Стандарт хангалт %	хувь	99.2	100.0	96.1	96.1
А, В-ийн эзлэх %	хувь	62.1	64.8	38.1	58.8



ГУРАВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

3.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 06 сарын эцэст

Боловсролын түвшингээр	2015. VI	2016.VI	2017.VI	2018. VI	$\frac{2018. VI}{2015. VI}$	$\frac{2018. VI}{2017.VI}$
	хүний тоо				хувь	
ДҮН	1 451	1 018	1 663	926	63.8	55.7
Үүнээс: Эмэгтэй	833	535	805	436	52.3	54.2
Магистр, доктор	4	10	6	1	25.0	16.7
Дээд боловсролтой	389	250	398	168	43.2	42.2
Тусгай дунд	167	125	147	40	24.0	27.2
Техник мэргэжлийн	134	119	145	57	42.5	39.3
Бүрэн дунд	504	352	763	575	114.1	75.4
Бүрэн бус дунд	190	129	156	56	29.5	35.9
Бага	50	24	27	6	12.0	22.2
Боловсролгүй	13	9	21	23	176.9	2.2 ²

3.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 06 сарын эцэст

	Ажилгүй иргэдийн тоо		Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн хүний тоо	
	2017. VI	2018. VI	2017. VI	2018.VI	2017. VI	2018.VI
ДҮН	1663	926	198	164	387	1264
Айраг	181	64	31	15	32	109
Алтанширээ	22	33	4	7	10	60
Даланжаргалан	73	35	5	11	20	47
Дэлгэрэх	45	22	12	3	22	13
Иххэт	40	48	0	18	3	64
Мандах	45	22	9	19	0	51
Өргөн	70	24	23	18	68	47
Сайхандулаан	39	18	4	4	12	25
Улаанбадрах	32	18	3	21	21	53
Хатанбулаг	32	15	4	0	8	38
Хөвсгөл	27	7	15	10	16	20
Эрдэнэ	33	28	4	2	13	37
Сайншанд	222	432	53	23	126	500
Замын - Үүд	802	160	31	13	36	200

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар





3.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, 06 сарын эцэст

Салбарын ангилал	2017.VI	2018.VI
	Тоо	
Бүгд	300	245
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	9	2
Уул уурхай олборлох аж үйлдвэр	139	130
Боловсруулах үйлдвэрлэл	9	3
Цахилгаан, хий, уур, агааржуулалт		1
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа		5
Барилга	1	2
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ		1
Тээвэр агуулахын үйл ажиллагаа		8
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ		1
Мэдээлэл, холбоо	1	
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	3	12
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа		
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа		
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа		2
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	39	22
Боловсрол	21	10
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	15	18
Урлаг, үзвэр, тоглоом наадам	7	9
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	56	19
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн нэр төрлөөр нь салгаж тодорхойдох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ		
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа		

3.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, 06 сарын эцэст

Үзүүлэлт	2017. VI	2018. VI
	Тоо	
Бүгд	300	245
Менежер	10	1
Мэргэжилтэн	80	69
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	34	32
Контор, үйлчилгээний ажилтан	12	11
Худалдаа, үйлчилгээний ажилтан	42	17
ХАА, ой загас агнуурын ажилтан	1	2
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	28	19
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	62	36
Энгийн ажил мэргэжил	28	49
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	3	9

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



3.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангилалаар 06 сарын эцэст

Үзүүлэлт	2017. VI		2018. VI	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	тоо			
Бүгд	198	93	164	71
Менежер	9	2	2	2
Мэргэжилтэн	28	22	30	19
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	20	16	19	12
Контор, үйлчилгээний ажилтан	9	8	12	8
Худалдаа, үйлчилгээний ажилтан	34	23	14	8
ХАА, ой загас агнуурын ажилтан	1	0		
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	13	2	11	3
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	53	6	22	7
Энгийн ажил мэргэжил	29	13	45	8
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	2	1	9	4

3.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар, 06 сарын эцэст

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар	
			Байнга	Улирал
	тоо			
Бүгд	122	44	70	52
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	2	0	2	
Уул уурхай олборлолт	38	12	20	18
Боловсруулах үйлдвэрлэл	3	1	1	2
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж				
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент				
Барилга	42	9	31	11
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	8	6	8	
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	1	0	1	
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	16	13		16
Мэдээлэл холбоо				
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа				
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	5	0		5
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа				
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	3	0	3	
Боловсрол	1	1	1	
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	2	2	2	
Урлаг үзвэр тоглоом наадам				
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1	0	1	
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа				

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ДӨРӨВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

4.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА төрлөөр, жил бүрийн 06 сарын эцэст

	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2018 I-VI
	2017 I-VI	2018 I-VI	2017 I-VI
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	13 836.0	16 455.2	118.9
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	8 355.6	10 344.8	123.8
Тэтгэмжийн даатгалын сангийн	946.3	1 171.8	123.8
Эрүүл мэндийн даатгалын сангийн	2 772.8	2 752.8	99.3
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	1 380.4	1 711.9	124.0
Ажилгүйдлийн даатгалын сангийн	380.9	473.9	124.4
Нийгмийн даатгалын сангийн зарлага	19 274.8	22196.4	115.2
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	13 705.4	15 884.7	115.9
Тэтгэмжийн даатгалын сангийн	1 064.1	1 238.3	116.4
Эрүүл мэндийн даатгалын сангийн	2 986.8	3 441.3	115.2
ҮОМШӨ**-ний даатгалын сангийн	1 026.1	1 265.4	123.3
Ажилгүйдлийн даатгалын сангийн	492.4	366.7	74.5

** - ҮОМШӨ- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

4.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧДЫН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 06 сарын эцэст

Үзүүлэлт	ХЭМЖИХ НЭГЖ	2017 I-VI	2018 I-VI	2018 I-VI 2017 I-VI
1. Заавал даатгуулагч хүний тоо	тоо	14953	15826	105.8
Үүнээс: Аж ахуй нэгж, байгууллага	тоо	7213	7975	110.6
Төсөвт байгууллага	тоо	7740	7851	101.4
2. Олгосон тэтгэвэр	сая төгрөг	14095.1	16307.2	115.7
Үүнээс: Өндөр насны тэтгэвэр	сая төгрөг	10407.8	11942.9	114.7
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн тэтгэвэр	сая төгрөг	1518.8	1825.2	120.2
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	сая төгрөг	710.1	802.7	113.0
ҮОМШӨ-ний даатгалын сангийн тэтгэвэр	сая төгрөг	409.6	434.7	106.1
Цэргийн тэтгэвэр	сая төгрөг	1048.8	1301.7	124.1

Эх үүсвэр: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс



4.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 06 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2018 I- VI	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2018 I- VI
	2017 I- VI	2018 I- VI	2017 I- VI	2017 I- VI	2018 I- VI	2017 I- VI
	тоо		хувь	мянган төгрөг		хувь
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ	16122	21761	135.0	2907489.6	4050225.6	139.3
1. Халамжийн тэтгэвэр	1293	1325	102.5	729803.1	1120498.5	153.5
Ахмад настны тэтгэвэр	53	58	109.4	41010.4	48596.3	118.5
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	1240	1267	102.2	688792.7	1071902.2	155.6
2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж	1106	1036	93.7	357710.3	377224.8	105.5
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэнд олгосон тэтгэмж	1028	975	94.8	333516.4	353594.3	106.0
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	51	49	96.1	17866.7	19893.6	111.3
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	7	6	85.7	1896.5	2344.0	123.6
Ахмад настаныг гэртээ асрамжилж байгаа иргэн	11	5		3285.1	1328.9	40.5
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн	9	1	11.1	1145.6	64.0	5.6
3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн	998	951	95.3	330190.0	307390.5	93.1
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	362	230	63.5	193928.4	191150.5	98.6
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	595	689	115.8	127061.6	74280.0	58.5
Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/	37	4	10.8	3600.0	360.0	10.0
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	1	10	10.0 ²	2000.0	20000.0	10.0 ²
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	2	6	3.0 ²	2400.0	7200.0	3.0 ²
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	1	6	3.0 ²	1200.0	7200.0	6.0 ²
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн		6			7200.0	
4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал						
5. Нийгмийн халамжийн дэмжлэг тусламжаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зардал	5916	7702	130.2	507499.5	439513.5	86.6
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	3677	3499	95.2	162806.8	105552.5	64.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	159	182	114.5	27705.6	31180.3	112.5
Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн, сум, хорооны нийгмийн ажилтанд олгох урамшил					5125.3	
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт		2896			173888.0	
Банкны шимтгэл					1879.4	
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт	2080	1125	54.1	316987.1	121888.0	38.5
